



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/173

Арвайхээр

Төслийн удирдах хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.а, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч Өвөрхангай-2020” хөтөлбөрийн 2.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нэгдсэн үндэсний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Дэлхийн Худалдааны байгууллага хамтран хэрэгжүүлж буй “Малыг ялган тэмдэглэх, бүртгэх системийг сайжруулах” туршилтын төслийг Баянгол, Гучин-Ус, Уянга, Бат-Өлзий сумдад хэрэгжүүлэх удирдах хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

- Хорооны дарга:- Г.Баясгалан (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)
Гишүүд:- С.Цэдэнбалжир (аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
-А.Нямдаваа-(аймгийн Засаг даргын дэргэдэх Мал эмнэлгийн газрын дарга)
-Ж.Энхтуяа (аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)
-Г.Гантөмөр (Малыг ялган тэмдэглэх, бүртгэх системийг сайжруулах төслийн Орон нутгийн зохицуулагч)

2. Төслийн үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөлийг хангах, үр дүнтэй хэрэгжүүлэх, сайтар зохион байгуулж ажиллахыг Төслийн удирдах хороо (Г.Баясгалан)-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100371